

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТАГТ ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМЛЫН ТӨРӨЛ ЗҮЙЛНИЙ ХАМГААЛЛЫН АСУУДАЛД

Б.Одончимэг, Б.Цэрэннадмид, М.Ганболд

ХААИС-ийн харъяа Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн

### ХУРААНГУЙ

*Энэхүү судалгаагаар Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт “Байгалийн ургамлын тухай” Монгол улсын хуулийн хавсралт, Монгол Улсын ховор амьтдын зүйл (2001)-д багтсан нэн ховор 11 зүйл ургамал, БОНХЯ-наас гаргасан жагсаалтад багтсан 21 зүйл ховор ургамал, 5 зүйл ховор амьтан тэмдэглэж, тэдгээрийн тархацыг тогтоон, статус, ашиглалтын хэлбэрүүдийг тодорхойлсон. Уг тодорхойлолтыг үндэслэн биологийн төрөл зүйлийг хамгаалах зөвлөмж боловсрууллаа.*

**ТҮЛХҮҮР ҮГ:** Ургамлын зүйл, хөхтөн амьтан, тоо толгой, тархац

### СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Биологийн төрөл зүйл нь уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны зохисгүй нөлөөллийн улмаас газрын хөрс, хэвлийн элэгдэл эвдрэл ихсэж, ургамлан бүрхэвч сийрэгжин улмаар түүний бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх, тархац, нөөц хомсдох нэг шалтгаан болдог. Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “...Устах аюулд орж байгаа амьтан, ургамлыг хамгаалах, уугуул нутагт нь сэргээх, тарималжуулах ажлыг эрчимжүүлэх” ажлын хүрээнд 2012 онд “Байгалийн ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үндэсний хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулсан байдаг. УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021)”-ыг боловсруулан гаргасан. Уг цогц бодлогод тус нутгийн биологийн төрөл, зүйлийн хомсдлыг хязгаарлах, нэн ховор, ховор, ашигт ургамал, амьтны тархац, нөөцийг тогтоох, хамгаалах, зохистой ашиглах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар тодорхой тусгажээ. Энэхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх гол нөхцөл нь сум, аймаг, бүс нутаг тус бүрт биологийн төрөл зүйлийн судалгааг явуулж, баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөх явдал юм.

### СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Дархан-Уул аймгийн нутаг дахь ховордсон хөхтөн амьтан, нэн ховор ховор ургамлын бүртгэл, ашиглалтанд өртөмтгий байдал, тархац,

нөөцийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

1. Дархан-Уул аймгийн хэмжээнд нэн ховор, ховор ургамлын бүртгэл судалгааг гүйцэтгэх
2. Нэн ховор, ховор ургамлын тархац, нөөцийн мэдээллийн санг бүрдүүлж, ашиглалтын хэлбэрүүдийг тодорхойлох
3. Хөхтөн амьтдын тархац, сүрэглэл, сүргийн бүтцийг тодорхойлох, нягтшил, нөөц, байршилыг тогтоох
4. Дархан-Уул аймгийн хэмжээнд ховордсон амьтан ургамлын төрөл зүйлийг хамгаалах зөвлөмж боловсруулах

## СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ, АЧ ХӨЛБӨГДӨЛ

Дархан-Уул аймгийн нутагт ховордсон амьтан, ургамлын төрөл зүйлийн тархац, нөөцийг тогтоож, хамгаалах, зохистой ашиглах хөтөлбөрийг анх удаа боловсруулсан. Орон

нутгийн түвшинд биологийн төрөл, зүйлийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бодлого боловсруулахад энэхүү судалгааны үр дүн нь суурь материал болох ач холбогдолтой.

## СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

Нэн ховор, ховор ургамлын жагсаалтыг Монгол Улсын Улаан ном (1997, 2013), Ургамлын Улаан данс (2012), Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралт (1995), Засгийн газрын 1995 оны 153, 2004 оны 165 дугаар тогтоолын хавсралтад багтсан ургамлуудаас түүвэрлэн гаргасан. Ургамлын зүйлүүдийг тодорхойлохдоо И.А.Губанов (1996), В.И.Грубов (1982, 2008), Ш.Дариймаа нар (2009), Б.Цэрэннадмид (2013) нарын ном, бүтээлүүдийг ашиглав. Дархан-Уул аймгийн нэн ховор, ховор ургамлын тархац нутгийг хээрийн судалгаагаар тогтоон, тэдгээрийн тархалтын цэгүүдийг Garmin E-trex маркийн GPS-д тэмдэглэж, Arc GIS 9.3, Google

Earth Pro 7.2 программ ашиглан Дархан-Уул аймгийн 1:100000 масштабтай газрын зурагт буулгасан болно.

Ан амьтдын нягтшил, нөөцийг тогтоох хээрийн судалгааны ажлыг А.Г.Банников (1954), Д.Цэнджав (1988), Ж.Бадамханд (2011) нарын бүтээлүүдийг ашиглан “Монгол орны хөхтөн амьтдын экологи биологийн судалгааны нэгдсэн арга зүй”, “Монгол орны байгалийн янз бүрийн бүс, бүслүүрийн монгол тарваганы нөөцийг тогтоох аргачлал”, “Тал хээрийн туруутны нөөцийг тогтоох арга зүй”, “Ойн туруутны нөөцийг тогтоох арга зүй”-н дагуу хийж гүйцэтгэсэн.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Дархан-Уул аймгийн нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн тархалт Монгол улсын "Байгалийн ургамлын тухай" хуулийн хавсралт (1995)-д 133 зүйлийн нэн ховор ургамлыг, Засгийн газрын 153 дугаар тогтоол (1995), 165 дугаар тогтоол (2004)-ын хавсралтад 353 зүйлийн ховор ургамлыг тус тус багтааж ашиглалтыг нь хязгаарласан байдаг. Хамгийн сүүлд шинэчлэгдсэн Монгол Улсын Улаан ном (2013)-д нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай нэн ховор, ховор 135 зүйлийн дээд ургамлыг оруулсан байна. Монголын Ургамлын улаан дансанд (2012) нийт 110 зүйл орсноос 16 зүйл нь нэн ховор, 39 зүйл нь устаж болзошгүй, 55 зүйл нь эмзэг гэсэн ангилалд багтжээ. Бид судалгааны үр дүнд дээрх хуулийн хавсралтад багтсан нэн ховор, ховор 32 зүйл ургамал тэмдэглэж, тэдгээрийн тархацыг тогтоон (Зураг

1, 2), статус, ашиглалтын хэлбэрүүдийг тодорхойлсон (Зураг 3, 4).

Тус нутгийн ургамлын аймагт 11 зүйлийн нэн ховор, 21 зүйлийн ховор ургамал тархсанаас 3 зүйл Монгол Улсын улаан номонд, 5 зүйл Монголын Ургамлын Улаан дансанд тус тус багтсан байдаг. Нэн ховор ургамлаас *Solidago dahurica*, *Gentiana macrophylla*, *Vincetoxicum sibiricum*, *Lilium martagon*, *Cypripedium guttatum*, *C.macranthum*, *C.calceolus*, *Rhodiola rosea*, *Hedysarum fruticosum*, *Rhododendron dahuricum*, *Caryopteris mongolica*, ховор ургамлаас *Valeriana officinalis*, *Saposhnikovia divaricata*, *Trifolium repens*, *Adonis sibirica*, *Anemone reflexa*, *Paeonia anomala*, *Stellaria dichotoma*, *Sparganium glomeratum*, *Chelidonium majus*, *Allium victoralis*, *Cacalia hastata*, *Gentiana barbata*, *Ephedra sinica*, *Glycyrrhiza uralensis*, *Polygonum viviparum*,


*Pteridium aquilinum*, *Malus baccata*, Улаан *macranthum*, *C.calceolus*, *Rhodiola rosea*,  
 номонд багтсан *Cypripedium macranthum*, *Caryopteris mongolica*, *Paeonia anomala* зэрэг  
*C.calceolus*, *Saposhnikovia divaricata*, Ургамлын зүйлүүд тус тус тохиолдоно (Хүснэгт 1).  
 Улаан дансанд бүртгэгдсэн *Cypripedium*

Хүснэгт 1

Дархан-Уул аймгийн нутагт ургаж нэн ховор, ховор ургамлын статус, ашиглалтын хэлбэр, тархалт

№	Зүйлийн нэр	Статус		Ашиглалтын хэлбэр			
		Нэн ховор	Ховор	Улаан номонд Улаан дансанд Субэндемик	Эмийн	Хүнсний Гоёл чимэглэлд Худалдаалах	Бэлгээр, хадлан
1	<i>Solidago dahurica</i> Kitag.- Дагуур алтаргана	+			+		
2	<i>Gentiana macrophylla</i> Pall.- Томцэцэгт дэгд	+			+		
3	<i>Gentiana barbata</i> Froel.- Хэвтээ дэгд		+		+	+	
4	<i>Caryopteris mongolica</i> Bge. – Монгол догар	+		+	+		
5	<i>Vincetoxicum sibiricum</i> Desne.-Сибирь ерөндгөнө	+			+		+
6	<i>Lilium martagon</i> L. – Буржгар сараана	+			+		
7	<i>Rhodiola rosea</i> L. – Алтангагнуур	+		+	+		
8	<i>Cypripedium macranthum</i> Sw.-Том цэцэгт саадганцэцэг	+		+	+		
9	<i>Cypripedium guttatum</i> Sw. – Толбот саадганцэцэг	+			+		
10	<i>Cypripedium calceolus</i> L. – Шар саадганцэцэг	+		+	+		
11	<i>Hedysarum fruticosum</i> Pall. – Сөөгөн шимэрс	+			+		+
12	<i>Rhododendron dahuricum</i> L. – Дагуур тэрэлж	+			+		
13	<i>Valeriana officinalis</i> L. – Эмийн бамбай		+		+		
14	<i>Adonis sibirica</i> Patr.ex Ldb. – Сибирь алтанхундгана		+		+		
15	<i>Anemone reflexa</i> Steph. – Нумараа яргуйжин		+				
16	<i>Paeonia anomala</i> L. – Ягаан цээнэ		+	+	+		
17	<i>Stellaria dichotoma</i> L. – Ацан ажигана		+		+		+
18	<i>Trifolium repens</i> L. – Мөлхөө хошоонгор		+		+		+
19	<i>Chelidonium majus</i> L. – Их шүүдэргэнэ		+		+		
20	<i>Allium anisopodium</i> L. – Сарвуун сонгино		+		+	+	+
21	<i>Allium odorum</i> L. – Анхил сонгино		+		+	+	+
22	<i>Allium victorialis</i> L. - Халиар		+		+	+	+
23	<i>Cacalia hastata</i> L. – Илдэн игүүшин		+		+		+
24	<i>Ephedra sinica</i> Stapf. – Нангиад зээргэнэ		+		+		+





3-р зураг. Нэн ховор, ховор ургамлын тархац, ашиглалтын хэлбэрний давхцсан байдал

Сүүлийн жилүүдэд ховор бөгөөд ашигт ургамлын зүйлүүдийг аж ахуйн хэрэгцээнд зориулан хэт ихээр түүж ашиглаж байгаагаас үүдэн тэдгээрийн тархац улам бүр хомсдож байна. Тухайлбал: *Cacalia hastata*, *Valeriana officinalis*, *Thymus gobicus*, *Sanguisorba officinalis*, *Allium victoralis*, *Polygonum viviparum*, *Pteridium aquilinum*, *Dianthus superbus*, *Glycyrrhiza uralensis*, *Saposhnikovia divaricata* зүйлүүд нь бүгд ховор ургамлын жагсаалтад багтсан байдаг бөгөөд Дархан-Уул аймгийн зөвхөн зүүн хэсэг болох Хүйтний гол, Мөөл уул, Хар ямаат, Гахайн овоо уул, Модот өрөмтийн уул, Хар бэлчирийн ам, Углуу уул зэрэг газруудаар ховор тохиолддог. Түүнчлэн нэн ховор, ховор ургамлын тархац бүхий нутаг дэвсгэр бэлчээр, хадлан, газар тариалан, уул уурхайн олборлолтын эдэлбэр газартай давхцсанаар тухайн зүйл ургамлыг ховордоход хүргэх гол шалтгаан болж байна (Зураг 3).

#### **Дархан-Уул аймгийн нутагт ховордсон хохтон амьтад**

Дархан-Уул аймгийн ан амьтдын тархац нутгийн зарим хэсэгт газар тариалан эрхлэх, зам тээвэр, ган зуд, отор, нүүдэл хийх болсноор тариалангийн талбай ба малын бэлчээр, зэрлэг

амьтдын эзэмшил нутгийн давхцал үүсэж ан амьтад дасан зохицсон идээшсэн нутгаасаа дайжин шахагдан зайлж амьдрах орчны доройтолд орж, байнгын тогтвортой тайван амьдрах эзэмшил нутаг бага учраас үржил өсөлт алдагдаж ан амьтдын сан хөмрөг хомсдох шалтгаан болж байна. Зэрлэг гахай тархачын хувьд Мөөл уул, Өвөлжөөт, Их нарст, Тийрэгт, Шивэртийн голын эх, Бүхт нарийн, Элээт өндөр, Могойн даваа, Могойт өндөр, Хар модот, Гахайн овоо, Хар ямаат уулын ой бүхий нутгийн хүрээг бараг бүхэлд нь хамрана. Дархан-Уул аймгийн 270.1км<sup>2</sup> нутагт зэрлэг гахай тархан нутагшдагаас судалгаагаар 4 сүрэгт 19 бодгаль тохиолдсон ба нийт 270км<sup>2</sup> тархац талбайд 27 зэрлэг гахайн нөөцтэй боловч эрчимтэй агнуураас болж ховордож байна. Ой бүхий нутагт хийсэн хээрийн судалгаагаар хүрэн баавгай тохиолдоогүй бөгөөд Шарын гол сумын Гахайт, Моностойн ам зэрэг газруудад улирлын чанартай ганц нэгээр ирдэг гэсэн нутгийн иргэдийн ам мэдээ байдаг.

Бид судалгаагаа дүнд Дархан-Уул аймгийн нутагт нийт 4 багийн 30 зүйлийн том хөхтөн байгааг тогтоож, тэдгээрийн тархалт байршил, нягтшилыг бодож гаргасан (Хүснэгт 2).

Дархан-Уул аймгийн хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл

№	Зүйлийн нэр	IUCN Read List (2006)Global category	Монгол Улсын ховор амьтдын жагсаалт 2001	Монол Улсын улаан ном, 1987,1997	CITES 1,2 хавсралт	Улаан данс 2006	Амьтны аймгийн тухай хууль	
<b>Ац туруутны баг - Artiodactyla</b>								
1	Молцог хандгай	<i>Alces Alces</i>	АӨ	+	+	-	УБ	ХО
2	Халиун буга	<i>Cervus elaphus</i>	АӨ	+	+	-	УБ	ХО
3	Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	АӨ	+	-	-	ХБ	НХ
4	Бөр гөрөөс	<i>Capriolus pygargus</i>	АӨ	-	-	-	АӨ	АЗ
<b>Мах идэштний баг - Carnivora</b>								
9	Хүрэн баавгай	<i>Ursus arctos</i>	АӨ	+	-	-	МД	АЗ
10	Шилүүс мий	<i>Lynx lynx</i>	ХБ	+	-	-	ХБ	АЗ
11	Мануул мий	<i>Felis manul</i>	ХБ	-	-	-	ХБ	АЗ
12	Нохой зээх	<i>Gulo gulo</i>	ЭМ	-	-	-	АӨ	АЗ
13	Саарал чоно	<i>Ganis Lupus</i>	АӨ	-	-	-	ХБ	АЗ
14	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	АӨ	-	-	-	ХБ	АЗ
15	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	АӨ	-	-	-	ХБ	АЗ
16	Ойн булга	<i>Martez zibellina</i>	АӨ	-	-	-	ЭМ	АЗ
17	Халздай дорго	<i>Meles meles</i>	АӨ	-	-	-	АӨ	АЗ
18	Цагаан үен	<i>Mustela erminea</i>	АӨ	-	-	-	АӨ	-
19	Хотны үен	<i>Mustela nivalis</i>	АӨ	-	-	-	АӨ	-
20	Модны үен	<i>Mustela sibirica</i>	АӨ	-	-	-	АӨ	-
21	Өмхий хүрнэ	<i>Mustela eversmanni</i>	АӨ	-	-	-	АӨ	-
<b>Туулай хэлбэртний баг - Lagomorpha</b>								
22	Чандага туулай	<i>Lepus timidus</i>	АӨ	-	-	-	АӨ	АЗ
23	Боролзон туулай	<i>Lepus tolai</i>	АӨ	-	-	-	АӨ	АЗ
<b>Мэрэгчдийн баг - Rodentia</b>								
24	Бараан хэрэм	<i>Sciurus Vulgaris</i>	ХБ	-	-	-	ХБ	АЗ
25	Монгол тарвага	<i>Marmuta sibirica</i>	АӨ	-	-	-	УБ	АЗ
26	Заарт харх	<i>Ondatra zibethica</i>	АӨ	-	-	-	-	АЗ
27	Замба жирх	<i>Tamias sibiricus</i>	АӨ	-	-	-	АӨ	-
28	Сүүлэрхэг зүрам	<i>Citellus undulatus</i>	АӨ	-	-	-	АӨ	-
29	Сохор номин	<i>Myospalax aspalax</i>	АӨ	-	-	-	МД	-
30	Шивэр алагдаага	<i>Allagdaga sibirica</i>	АӨ	-	-	-	АӨ	-

**Тайлбар:** АӨ – анхааралд өртөөгүй, МД – мэдээлэл дутмаг, УБ – устаж болзошгүй, ХБ – ховордож байгаа, ЭМ – эмзэг, ХО – ховор, АЗ – ангийн зөвшөөрөл олгодог.


Хээрийн судалгаагаар Хонгор сумын Нарст өндөр уул, Өвөлжөөт өндөр уул, Шивэртийн ам, Могойт өндөр уул, Хүйтэн голын эх, Хар модот уул, Гахайн овоот уулын эзгүй зэлүүд ойн доод захтай залган орших торлог, бургас ихтэй голын хөндий, амуудын ёроолын намаг ихтэй газруудад 15 км<sup>2</sup> талбайд 3 молцог хандгай бүртгэгджээ. Ойн бүсэд хийгдсэн судалгааны үр дүнгээр 33.9

км<sup>2</sup> тархац нутгийн 1000 га тутамд 0.2 бодгаль ноогдох нягтшилтайгаар 7 молцог хандгай байна (Зураг 4).


Халиун бугын гол тархац нутаг нь Мөөл уул, Их нарст, Өвөлжөөт өндөр, Тарвагат, Могойн даваа, Могойт өндөр, Хүйтний гол орчмын 80.5км<sup>2</sup> нутагт тархацтай байна. Буга 3, согоо 6, илий 4 нийт 13 бодгаль тэмдэглэгдсэнийг үндэслэн

Дархан-Уул аймгийн 80.5км<sup>2</sup> нутагт /1000 га-д 0.06 бодгаль нягтшилтай/ 23.5 толгой нөөцтэй

гэж үзэж болохоор байна (Зураг 5).



4-р зураг. Хандгайн тархац



5-р зураг. Халиун бугын тархац

Бор гөрөөсний гол тархац нутаг нь Их углуу уул, Өрөмтий, Хар билчэр, Тийрэгт, Их нарст, Мөөл уул, Өвөлжөөт өндөр, Шивэртийн голын эх, Майнт уул, Бухын овоо, Бүхт нарийн уул, Хар ямаат, Гахайн овоо, Могойт өндөр, Тарвагат, Элээт өндөр, Самбарын эрээн, Их уургат зэрэг нийт ой бүхий 542.3км<sup>2</sup> талбайд тархацтай. Хээрийн судалгаагаар нийт 33 бодгаль тоологдсон бөгөөд бор гөрөөсний тархац 542.3км<sup>2</sup> нутагт 54 толгой нөөцтэй, 10км<sup>2</sup>-д 0.1 бодгаль нягтшилтай.

Аймгийн нийт газар нутгийн 60% буюу 19200км<sup>2</sup> талбай саарал чонын байршил, тархацтай. Дархан-Уул аймгийн хэмжээнд 16000 км<sup>2</sup> нутагт 1000 га-д 0.007 бодгаль ноогдох нягтшилтайгаар шар үнэг тархан байршиж байгаа бол 12500км<sup>2</sup> нутагт хярс үнэг тархан байршиж 1000га-д 0.05 бодгаль ноогдох нягтшилтай.

Орхон сумын Буурал уул, Цогдоо, Дэлгэр, Хонгор сумын Ноён хонгор уул, Цогт өндөр, Шийр уул, Төмөрт толгой, Их углуу, Хар билчэр, Зэдэрийн өндөр, Мөөл уулын өвөр, Өвөлжөөт өндөр уулын өвөр зэрэг 45.3 км<sup>2</sup> нутагт тарвага тархацтай байх ба нөөц нь 272 толгой байна.

Чандага туулай 9800км<sup>2</sup> нутагт хамгийн элбэг буюу 10км<sup>2</sup> талбайд 0.6% нягтшилтайгаар 588 толгой нөөцтэй.

Заарт харх Орхон сумын Хараа голын Цагаан тохой орчмын 44.4км<sup>2</sup> талбайд 1.5% нягтшилтай нийт 66 толгой нөөцтэй.

Цаашид бараан хэрэм, зурам болон бусад мэрэгчид, хоёр нутагтан, мөлхөгчид, шувуу, загасны судалгааг нарийвчлан хийж амьтны аймгийн мэдээллийн санд оруулах шаардлага байна.

## ДҮГНЭЛТ

1. Тус аймагт 11 зүйлийн нэн ховор, 21 зүйлийн ховор ургамал тархсанаас 3 зүйл (*Cypripedium macranthum*, *C.calceolus*, *Saposhnikovia divaricata*) нь Монгол Улсын улаан номонд, 5 зүйл (*Cypripedium macranthum*, *C.calceolus*, *Rhodiola rosea*, *Caryopteris mongolica*, *Paeonia anomala*) нь

ургамлын Улаан дансанд багтсан. Нэн ховор, ховор ургамлын тархац бүхий нутаг дэвсгэр газар тариалан, уул уурхайн олборлолтын эдэлбэр газартай давхцсан нь тухайн зүйл ургамлыг ховордоход хүргэх шалтгаан болж байна.

2. Тус аймагт 4 багийн 30 зүйл амьтан тархснаас 5 зүйл (*Alces Alces*, *Cervus elaphus*, *Sus scrofa*, *Ursus arctos*, *Lynx lynx*) нь Монгол Улсын ховор амьтдын жагсаалтад багтсан, 2 зүйл (*Alces Alces*, *Cervus elaphus*) нь Монгол улсын улаан номонд орсон. Молцог хандгай (*Alces Alces*) нь тус аймгийн нутахт 33.9км<sup>2</sup> талбайд 7 тоо толгой нөөцтэй, 10км<sup>2</sup> талбайд 0.2 %-ийн нягтшилтай, халиун буга (*Cervus elaphus*) нь 80,5км<sup>2</sup> талбайд 26 тоо толгой нөөцтэй, 10 км<sup>2</sup> талбайд 0.2 %-ийн нягтшилтай байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Банников А.Г. 1954. Млекопитающие. Монгольской Народной Республики. Москва.
2. Бадамханд Ж. 2011. Монгол орны агнуурын амьтдын лавлагаа. УБ.
3. Грубов В.И. 1955. Конспект флоры Монгольской Народной Республики, *Тр. Монг. Комиссий*, М., Л., Изд. АН СССР.- 67:307.
4. Грубов В.И. 1982. Определитель сосудистых растений Монголий. Л: Наука.: 441.
5. Грубов В.И. 2008. Монголын гуурет ургамал таних бичиг. УБ.
6. Губанов И.А. 1996. Конспект флоры внешней сосудистые растения. М: 136.
7. Дариймаа Ш., ба бусад. 2009. Дархан-Уул аймгийн цоргот ургамлын аймгийн ангилалзүй, тархац, экологи, МУБИС Биологийн тэнхим. *Эрдэм шинжилгээний бичиг*, 2: 98-109.
8. Монгол Улсын Улаан ном. 1997. УБ: Admon. 132.
9. Монгол Улсын Улаан ном. 2013. УБ: Admonпринт. 535.
10. Монголын Ургамлын Улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл. 2012. УБ.: 189.
11. Цэнджав Д. 1988. Монгол орны хөхтөн амьтан. УБ.
12. Цэрэннадмид Б. 2013. Особенности флоры на территориях Дархан-Уул аймака Монголий. *Ботанические исследования в Сибири*. Красноярск.: 21: 91-95.

## ABSTRACT

*This research of rare large mammals and the distribution of rare and scarce plant resources in and around the area of Darkhan-Uul province has been performed to build a database for the registration, exposure to usage and distribution of rare large mammals and rare and scarce plants in the above-mentioned area. As a result of the research, we have discovered that there are 21 species of scarce and 11 species of rare plants in Darkhan-Uul and determined their status and usage types by selecting the list of rare and scarce plants in the area of Darkhan-Uul province according to the 353 plant species listed in the annex to the Mongolian Government Order No. 165 of 2004, Order No. 153 of 1995, and in the annex to the Mongolian laws protecting natural plants, and to the plants included in Red List (2012), Red Book of Mongolia (1997, 2013). We have also conducted a research on large mammals in four soums of Darkhan-Uul province and we have defined that there are 30 different species of 4 orders of large mammals and worked out their range or distribution, location, and density. We created Guidelines on Protecting Biological Species in Darkhan-Uul based on our research.*